



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/39

Хажуу шинэ-Ус

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгалийн ургамлын тухай хуулийн 7.1, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/89 дүгээр тушаал, Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/99 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бэлчээрийн талбайд үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Сарангэрэл (Засаг даргын орлогч)

Нарийн бичиг: Э.Лайжинханд (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Гишүүд: Б.Гүнсэнтүг (1 дүгээр багийн Засаг дарга)

Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга)


Б.Даваасүрэн (Здугаар багийн Засаг дарга)

2. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх ажиллагааг зохион байгуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдүүлэхийг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Гэрээ байгуулж захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Сарангэрэл)-д даалгасугай.

4. Оготно устгалын ажлын гүйцэтгэлийг үнэлж нүд үзэн хариуцлагатайгаар хүлээн авахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (А.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т. АРИУНАА